

**1920-ИОД ОНООС 1980-ААД ОНЫ ҮЕД МОНГОЛД ХИЙГДСЭН  
УЛС ТӨРИЙН СУДАЛГААНЫ ТУХАЙД****А.Жамбал**

ФСЭХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Эртний үеэс эх үндэстэй монголын улс төрийн уламжлалт сэтгэлгээ XIX-XX зууны зааг хүртэл үргэлжилэн хөгжжээ. Тэр цагийн монголын нийгмийн амьдралд гарч өрнөсөн өөрчлөлт, гадаад орчин нөхцөлийн хувирлыг тусгасан, өмнөх үеийнхээс шинэ соргог үзэл санааг агуулсан нийгэм-улс төрийн дэвшилт ардчилсан сэтгэлгээ хоёр зууны дээрхи зааг үеэс үүсэн өрнөж 1920-иод он гартал үргэлжилсэн байна. Эл сэтгэлгээ 1911 оны монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал, улмаар 1921 онд ялсан ардын хувьсгалын үзэл санааны үндэс болж үйлчилжээ.

1920-иод оноос 1990 он хүртлэх 70-аад жилд марксист онол, сургаалд үндэслэсэн нийгэм-улс төрийн шинэ сэтгэлгээ үүсэн хөгжиж түүний хүрээнд улс төрийн олон талтай судалгаа хийгдэж, зуугаар тоологдох ном зохиол нийтлэгдэн гарчээ. Энэхүү асуудлыг тусгайлан авч үзэж судлах хэрэгтэй юм. Энэ үед манай оронд хэдийгээр марксист ганц онол, арга зүйг догматик байдлаар баримталсан ч гэсэн ерөнхий чиг шугам, шинж чанар, агуулга, судалгааны арга, бичлэгээрээ орчин цагийн нийгмийн ухаан үүсэн бий болж хөгжсөн билээ. Түүний хүрээнд улс орон, төр, нам, олон нийтийн байгууллага, төрийн гадаад харилцаа, бодлого, улс төрийн сэтгэлгээ, түүхэн бие хүмүүсийн намтар түүх зэрэг олон талтай асуудлуудыг шинжлэн авч үзсэн улс төрийн шинж агуулгатай судалгаа хийгдсэн байна. Чухам энэхүү улс төрийн судалгаа 1990-ээд оны эхэн үеэс манай оронд улс төрийн шинжлэх ухаан харьцангуй богино хугацаанд үүсэн тэрлэж цааш хөгжих эхлэлийн хөрс суурь болсон билээ.

Манай орны нийгмийн шинжлэх ухааны хүрээнд 1920-иод оноос 1980-аад онд хийгдсэн улс төрийн чанартай судалгааг авч үзсэн асуудал, хандсан аспект, агуулгыг нь харгалзан үзэж дотор нь 1) улс төрийн түүх, 2) төр, нам, олон нийтийн байгууллага, улс төрийн систем, 3) төрийн гадаад бодлого, олон улсын харилцаа, 4) төрийн зүтгэлтэн, түүхэн бие хүмүүс, 5) улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаа, 6) улс төрийн ерөнхий мэдлэг бүрдүүлж боловсруулах талаархи судалгаа гэсэн ерөнхий чиглэл, салбараар ангилан авч үзэж болох юм.

1921 онд ардын хувьсгал ялж монголын нийгмийг үндсээр нь өөрчлөн байгуулах болсон үеэс засгийн эрхийг дангаараа барих болсон МАХН, төрөөс тус оронд орчин цагийн нийгмийн шинжлэх ухаан, түүний дотор түүх, хэл бичгийн ухааныг тэргүүлэх чиглэлтэй болгож үүсгэн хөгжүүлэхэд ихээхэн анхаарчээ. МАХН-ын 1924 онд хуралдсан IV их хурал, засгийн газраас нам, ардын хувьсгал болон ер нь монголын түүхийг бүхэлд нь шинээр судлан боловсруулах шийдвэр гаргасан нь түүх судлалд чухал түлхэц болжээ. Улмаар БНМАУ-ыг тунхагласан хийгээд Улсын анхдугаар үндсэн хуулийг баталсны 10 жил, Ардын хувьсгалын 13 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх наадмын комиссоос эдгээр түүхт ойнуудын өмнө Монголын бүрэн түүхийг таван ботиор зохиож нийтлүүлэх шийдвэр гаргасан байна.

Эдгээр шийдврийг хэрэгжүүлэхэд чиглэсэн түүхийн судалгааны үр дүнд бичигдсэн ном зохиолууд үндсэндээ улс төрийн түүхийн шинж агуулгатай байсан гэж үзэх үндэслэлтэй юм. Тийм зохиол бүтээлийн тоонд юуны өмнө Х.Магсаржавын бичсэн "Монгол улсын шинэ гарсан түүх" (гар бичмэл таван дэвтэр. Эл бүтээлийг



1994, 2010 онд кирилл үсгээр хэвлүүлжээ), Уулын өвгөн “Монгол газар бошгыг халах явдлыг тулгуур босгосны товч түүх” УБ.,1926; Ойдов, Цэцэнбилэгт “МХЗЭ-ийн түүхэнд холбогдох зүйлс” УБ.,1926; Ч.Бат-Очир. “Монголын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг”.УБ.,1927; Г.Дэмид.”Улаан цэргийн хөгжсөн түүх”. УБ., 1931; А.Амар. “Монголын товч түүх”. Тэргүүн дэвтэр. УБ.,1934; Д.Дэндэв. “Монголын товч түүх”. Дөрөвдүгээр дэвтэр. УБ.,1934; Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид. “Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх”.УБ.,1934; Х.Чойбалсан.”Ардын үндэсний хувьсгалт цэргийн агуу их хөгжлийн товч зам”; Г.Наваан-Намжил. “Монголын автономитын түүх.Гар бичмэл”; Б.Буянчуулган. “Манжаас монголыг эзэрхсэн үеийн хэрэглэгдэхүүн”.УБ., 1936; Цэргийн улс төрийн газраас эрхлэн хэвлүүлсэн “БНМАУ бол манай эх орон мөн”. Тэргүүн доорд дэвтэр. УБ., 1939 зэрэг олон ном бүтээл багтаж орно.

МАХН-аас 1940-өөд оноос хойшхи үед ч түүхийн судалгаа болон нийгмийн ухааны бусад салбар, чиглэлийг хөгжүүлэх талаар чухалчлан анхаарахын хамт үзэл суртлын хяналт тавьж байв. Энэ үед Л.Дугарсүрэнгийн “Монголын ард түмний тусгаар тогтнолын төлөө тэмцэл”. УБ., 1943; Л.Тойв. “Хувьсгалт цэргийн 25 жил”. УБ., 1946; түүнчлэн баярт зориулсан түүхийн судалгааны бүтээлүүдийн эмхтгэлүүдийг 1941, 1944, 1946 онд гаргаж байжээ.

Монгол-зөвлөлтийн эрдэмтэдийн хамтран туурвисан анхны том бүтээл “БНМАУ-ын түүх” нэгэн боть зохиол 1954 онд нийтлэгдсэнээс хойш улсын болон МАХН-ын түүхийн янз бүрийн асуудлаар эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, диссертацийн ажил олноор бичигдсэн байна.

1966-1969 онд “БНМАУ-ын түүх” гурван боть суурь бүтээл, 1967 онд “МАХН-ын товч түүх” (эл бүтээлийн бүлгүүдийг “намын амьдрал” сэтгүүлийн 1963-1964 оны дугааруудад цувруулж нийтэлсэн, 1964 онд товхимол хэлбэрээр хэвлүүлсэн бөгөөд 1970 онд 1967 оны хэвлэлийг тэр хэвээр нь, 1985 онд нэмж засварлан гурав дахь удаа хэвлэгджээ) хамтын бүтээл нийтлэгджээ. Эдгээр бүтээлд тухайн үеийн үзэл суртлын хатуу хяналт, марксизмыг ягштал баримталсан догматик сэтгэлгээний нөлөөгөөр үзэл сурталжсан, түүхэн үнэнийг бүрхэгдүүлсэн, XX зууны монголын бодит байдлыг зөвтгөж магтсан зэрэг дутагдалууд байгаа хэдий боловч бүхэлдээ монголын нийгэм, түүний аж ахуй, соёл, хүн ардын аж байдлыг иргэний түүхийн аспектээр тусгасны хамт монголын төр, түүний байгууллагууд, МАХН, олон нийтийн байгууллагын түүхийг улс төрийн түүхийн үүднээс авч үзэж нэгтгэн дүгнэсэн байна. Тиймээс эдгээр бүтээлийг 1920-иод оноос 1960-аад онд хийгдсэн монголын улс төрийн түүхийн судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж тусгасан тэр цагийн түүхийн ухаан, улс төрийн түүхийн сэтгэлгээний хөгжлийг илэрхийлэх шинжлэх ухааны гол баримт гэж үзэх учиртай.

1920-иод оноос 1990 –ээд оны эхэн бие хүртлэх үед төр, улс төрийн нам, улс төр-олон нийтийн байгууллагын шинж чанар хослосон үйлдвэрчний эвлэл, залуучууд, эмэгтэйчүүд, хүүхдийн байгууллага, бүхэлдээ улс төрийн системийн онол, түүх, түүнчлэн хувьсгал, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, анги, ангийн тэмцэл, дайн, цэрэг арми, сонгуулийн асуудлаар олон талтай судалгаа хийгдэж хэдэн арваар тоологдох ном зохиол нийтлэгдэн гарчээ.

Тэдгээрийн дотроос зарим гол бүтээлийг дурдвал Ц.Балхаажавын бичсэн “Төрийн тухай асуудал ба ардын төрийн хувьсгалт үйл ажилагаа”. УБ.,1966; С.Жалан-Аажав. “Ардын хувьсгалт төрийн хууль тогтоох үйл ажилгааны үндсэн чиглэл”. (1921-1940).УБ.,1967; Б.Сангиданзан. “Хувьсгалт ардчилсан шатан дахь ардын төрийн гүйцэтгэсэн үндсэн үүргүүд”. УБ., 1974; С.Дамба. “БНМАУ-ын төрийн хөгжилт”. УБ.,1974; М.Санждорж “Ардын төрийн түүх”. УБ., 1974; Б.Содовсүрэн. “Хувьсгалын өмнөх монголын төр ба хууль цааз”. 1911-1920. УБ.,1989; Ц.Намсрай



"Капитализмыг алгассан орнуудад социалист нийгмийн давхрага үүсэж хөгжсөн нь". УБ.,1975; Б.Лигдэн. "МАХН бол социалист нийгмийн улс төрийн системийн удирдах хүч мөн". УБ.,1978; (эл бүтээл бүхэлдээ улс төр судлалын шинж чанартай байгаа юм), Ж.Болдбаатар. "Социалист байгуулалтанд МАХН-ын удирдах роль өсөн нэмэгдэж байгаа нь". УБ.,1982; Ц.Буянтогтох. "БНМАУ-ын улс төрийн системд МХЗЭ-ийн гүйцэтгэх үүрэг". УБ.,1985; О.Амархүү. "Төрийн захиргааны дээд байгууллагууд". УБ.,1986; улс төрийн намын түүх, онолын асуудлаар Л.Санжаа. "Намын программуудын тухай". УБ.,1967; С.Ичинноров. "Монгол ардын нам гэдэг хувьсгалт байгууллага". УБ.,1973; Н.Дамба. "МАХН-ын эгнээ хөгжиж бэхжсэн нь". УБ.,1975; С.Дамдинсүрэн. "МАХН дэлхийн коммунист хөдөлгөөнтэй холбоо тогтоож хөгжүүлсэн нь". (1921-1940). УБ.,1971; Д.Даш. "Ардын хувьсгалын манлай хүчин". УБ.,1972; Б.Лигдэн. "БНМАУ-ын гадаад харилцааг хөгжүүлэх талаар МАХН-аас явуулсан үйл ажиллагаа". 1945-1970. УБ.,1976; Б.Лхамсүрэн. "МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь". УБ.,1975; Г.Лхагвасүрэн. "Ардын хувьсгалын үе дэх МАХН-ын стратеги, тактикийн зарим асуудал". УБ.,1977; хамтын бүтээлүүд болох "МАХН ба Коммунист Интернационал" (орос хэлээр) УБ.,1979; "МАХН-ЗХУКН, Социализмын төлөө ах дүүгийн ёсоор хамтран тэмцсэн түүхэн туршлага". УБ.,1971; "МАХН үүсч хөгжихөд олон улсын коммунист хөдөлгөөний тусламжийн роль, ач холбогдол". УБ.,1978; Х.Магсаржав. "МАХН-ын эгнээ өргөжин бэхжсэн нь". (1921-1924). УБ.,1979; Б.Цэдэн. "Монгол –Зөвлөлтийн найрамдал ба МАХН". УБ.,1967; Лу.Бат-Очир. "Монгол оронд ард ангийн хувьсгалт нам үүсэн байгуулагдсан асуудалд". 1918-1921. УБ.,1979 зэрэг бүтээлүүд гарчээ.

Мөн энэ үед залуучууд, эмэгтэйчүүд, хүүхдийн байгууллагын талаар О.Бямбажавын бичсэн "Монголын хувьсгалт залуучуудын эвлэл". УБ.,1972; А.Маамуу. "МХЗЭ-ийн түүхээс". УБ.,1965; Д.Цэрэндорж. "Хувьсгалт уламжлал ба залуучууд". УБ.,1974; хамтын бүтээл болох "МХЗЭ-ийн зохион байгуулалтын үндэс". УБ.,1981; Э.Чимэдцэрэн. "БНМАУ-д эмэгтэйчүүдийг нийгмийн дарлалаас чөлөөлсөн түүхэн туршлага". УБ.,1976; Д.Зундуй. "БНМАУ-д эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг хамгаалж байгаа нь". УБ.,1979; С.Удвал. "Монголын эмэгтэйчүүд 60 жилд". УБ.,1981; Ш.Магван. "Монголын үйлдвэрчний эвлэлийн соёл, хүмүүжлийн ажил". УБ.,1971 зэрэг ном зохиол нийтлэгджээ.

Дайн, цэрэг арми, хууль хамгаалах, хянан шалгах байгууллагын талаар Л.Тойвон "Дайнууд ба армийн гарал үүсэл, түүний мөн чанар". УБ.,1943; хамтын бүтээл болох "БНМАУ-ын зэвсэгт хүчин". УБ.,1981; Д.Гомбосүрэн. "Хувьсгалын ардчилсан шатан дахь БНМАУ-ын зэвсэгт хүчний байгуулалтын зарим асуудал". УБ.,1983; Б.Даваасүрэн. "МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа". УБ.,1990; П.Дорж. "Улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх талаар МАХН-аас явуулсан бодлого". (1929-1939) УБ.,1969; хамтын бүтээл "Хязгаарын цэргийн түүхэн замнал". УБ.,1965; "Монголын ардын армийн дайчин замнал". УБ.,1979; Д.Шагдар, П.Дагвадорж. "Хилийн цэргийн 50 жил" УБ.,1983; М.Санждорж, Ч.Бавуу. "БНМАУ-ын хянан шалгах байгууллагын түүхэн замнал". УБ.,1982 зэрэг олон бүтээл нийтлэгджээ.

Хувьсгал, нийгэм-улс төрийн хөдөлгөөн, үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэл, анги, ангийн тэмцэлийн асуудлаар улс төрийн чанартай судалгаа хийгдсэний үр дүнд Н.Ишжамц. Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл (Амарсанаа, Чингунжав нарын бодлого). УБ., 1962; С.Норовсамбуу "Капитализмын өмнөх харилцаа ноёрхон байсан орнуудад ялсан ардчилсан ба социалист хувьсгалын харьцаа, онцлогууд". УБ.,1965; Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. УБ.,1969; хамтын бүтээл. Октябрийн хувьсгал ба Монгол орон. УБ.,1969; Ц.Балхаажав. БНМАУ-ын ангийн харилцааны



хөгжил.УБ.,1972; Ш.Нацагдорж.Ар монголд гарсан ардын хөдөлгөөн.УБ.,1956; мөн түүний Сум, хамжлага, шавь, ард.УБ.,1972; Д.Цэдэв.Их шавь.УБ.,1964; Б.Түдэв.БНМАУ-ын ажилчин ангийн түүх.УБ.,1963; Ш.Жумдаан.БНМАУ-д ажилчин анги, хоршоолсон ардын эдийн засгийн холбоо үүсч тогтож хөгжсөн тухай.УБ.,1978; Б.Лигүү.Монгол ардын хувьсгал ба шинэ сэхээтэн.УБ.,1971; С.Пүрэвжав, Д.Дашжамц. БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь (1921-1940).УБ.,1965 гэсэн бүтээлүүд нийтлэгджээ.

БНМАУ-дахь сонгууль, сонгуулийн тогтолцооны талаар Л.Тойвонгийн бичсэн "БНМАУ-ын сонгуулийн систем".УБ.,1950; И.Дашням."БНМАУ-ын сонгуулийн систем".УБ.,1975 бүтээлүүд гарчээ.

Төрийн гадаад бодлого, олон улсын харилцааны асуудлаар улс төрийн аспекттэй судалгаа хийгдэж түүгээр Ц.Пунцагноровын бичсэн "Америкийн империализм бол монголын ард түмний заналт дайсан мөн" гэсэн бүтээл 1953 онд нийтлэгдсэн бол Б.Лхамсүрэн 1958 онд "Внешняя политика МНР (1943-1957)" гэсэн сэдвээр, Б.Лигүү мөн 1958 онд "Из истории русско-монгольских отношений в конце XIX начале XX века" сэдвээр диссертаци бичиж дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Д.Хүрэлбаатар. Монгол гүрний элчин харилцаа.(XIII зуун) УБ., 1964; Ш.Сандаг.Монголын улс төрийн гадаад харилцаа (1850-1919). Тэргүүн дэвтэр.УБ.,1971; Н.Дангаасүрэн. Гурав дахь ертөнц. Эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал. УБ.,1977; хамтын бүтээл болох Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх (1921-1976).УБ.,1981; Ц.Самдангэлэг. Зөвлөлт-Монголын армиуд Халх голд Японы түрэмгийлэгчдийг бут цохисон нь. УБ.,1981; Л.Бат-Очир. МАХН фашизм, милитаризмын эсрэг тэмцэлд ард түмнээ зохион байгуулсан нь (1941-1945).УБ.,1985; С.Дамдинсүрэн. Монгол Ардын Хувьсгал-дэлхийн хувьсгалт үйл явцын бүрэлдэхүүн хэсэг.УБ.,1983; Ж.Бор. Монголын улс төрийн гадаад бодлого, дипломатын уламжлалын зарим асуудал.УБ.,1988; хамтын бүтээл "Өнөөгийн Ази: Дайн энхийн асуудал".УБ.,1989 бүтээлүүдийг нийтлүүлжээ. С.Дамдинсүрэн, Б.Лигдэн, Б.Лхамсүрэн нарын бичиж туурвисан бүтээлүүдийг дээр нэр зааж дурдсан билээ.

1940-өөд оноос хойш хийгдсэн түүхийн судалгааны хүрээнд монголын төр, цэрэг, намын зүтгэлтэн, удирдагчид бүхий түүхэн бие хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааг бодит баримт түшин, тэдний аж төрж, зүтгэн тэмцэж байсан түүхэн нөхцөл, цаг үетэй холбож авч үзэж судалсан олон ном бүтээл нийтлэгдсэн байна. Тэдгээр нь улс төрийн шинжлэх ухааны хошуучлал буюу лидер судлалын чиглэлтэй нэлээд ойролцоо байгаа нь ажиглагддаг. Гэхдээ энэ нь тэдгээр судалгаанд лидер судлалд баримталдаг үзэл баримтлал, арга зүй, ойлголт, ангилал, судалгааны аргуудыг хэрэглэсэн гэсэн үг биш юм.

Манай орны түүхийн ухаанд төр, цэрэг,намын нэрт зүтгэлтэнүүдийн амьдрал үйл ажиллагаа, намтарыг судлан бичих явдал 1940-өөд оноос чухал болон тавигдаж бие даасан ном зохиол нийтлэгдэх болсон байна. Гэхдээ үүнээс өмнө, тодруулж хэлбэл 1920-иод оноос Д.Сүхбаатар болон ардын хувьсгалд хүчин зүтгэсэн С.Магсаржав, Ц.Дамбадорж нарын намтар, үйл амьдралын талаар өгүүлэл дурсамж нийтлэгдсэн байжээ.

1940-өөд оноос түүхэн зүтгэлтэнүүдийн намтар судлал, бичлэг идэвхжсэн нь дэлхийн хоёрдугаар дайны үед хүмүүсийг цэрэг эх оронч үзлээр хүмүүжүүлэх зорилт нэн чухал болсонтой нягт холбоотой байв. Түүний үр дүнд Ш.Нацагдоржийн бичсэн "Сүхбаатарын намтар" зохиол 1943 онд нийтлэгдсэн нь Д.Сүхбаатарын амьдрал, цэрэг-улс төрийн үйл ажиллагааг шинжлэх ухааны үндсэн дээр судлан гаргасан анхны бие даасан зохиол болсон байна. Үүнээс өмнө "Маршал Чойбалсангийн бага нас" гэсэн товхимол 1942 онд, Х.Чойбалсангийн бичсэн "Ардын



Хатанбаатар Магсаржав” 1942 онд, Ц.Цэдэнжавын бичсэн “Хатанбаатар Магсаржав” 1941 онд, мөн түүний “Партизан Хасбаатар” зохиол 1942 онд нийтлэгдэж байжээ. Эдгээрийн дараа Г.Навааннамжилын бичсэн “Дайсны ард нэвтэрсэн нь”.УБ.,1944, мөн түүний “Жанжин Чойбалсан баруун замын байлдаанд”. УБ.,1945, мөн түүний “Зоригт баатар Тогтохын намтар”.УБ.,1946, Ш.Нацагдоржийн бичсэн “Манлайбаатар Дамдинсүрэнгийн товч намтар”.УБ.,1945, Ю.Цэдэнбалын бичсэн “Нөхөр Чойбалсангийн амьдрал, үйл явдлын тухай”.УБ.,1945 онд тус тус нийтлэгджээ. 1946 онд “Манай их удирдагч нөхөр Янжмаагийн 25 жилийн хувьсгалт бүтээл” гэсэн ном гарчээ.

1950-иас 1980-аад онд намтар судлал үргэлжилж арав гаруй ном зохиол нийтлэгдсэн нь: Х.Чойбалсан “Сүхбаатар бол МАХН-ын жолоодогч бөгөөд түүнийг зохион байгуулагч мөн” УБ.,1955; Б.Ширэндэв “Хичээнгүй сайд Цэрэндорж (1868-1928)” УБ.,1965; “Сүхбаатарын тухай дуртатгалууд” УБ.,1965; Д.Ядамсүрэн “Ардын төрийн ахмад зүтгэлтэн Балингийн Цэрэндорж” УБ.,1967; Л.Бат-Очир, Д.Дашжамц. “Д.Сүхбаатарын намтар” УБ.,1969; Б.Ширэндэв “Ардын Хатанбаатар Магсаржавын намтар” УБ.,1978; С.Ичинноров “Монголын ард түмний гарамгай хүү” УБ.,1983 (Сүхбаатарын тухай-А.Ж); Д.Даш “Д.Сүхбаатарын тухай түүхэн тэмдэглэл” УБ.,1988; А.Дашням “Солийн Данзан” УБ.,1990; Л.Бат-Очир “Бодоо сайд” УБ.,1991 гэсэн бүтээлүүд болно.

1990-ээд оноос зүтгэлтэн түүхэн бие хүмүүсийн намтар судлал эрс идэвхжиж урьд нь үзэл суртал, улс төрийн тодорхой учир шалтгаануудын улмаас авч үзэж судалж байгаагүй, бие даасан ном зохиол бичигдээгүй төр, нам, цэргийн зүтгэлтэнүүдийн талаар олон ном бүтээл нийтлэгдэн гарсныг тэмдэглэх хэрэгтэй.

Тийнхүү 1990-ээд оноос өмнө хийгдэж байсан улс төрийн түүхийн судалгааны хүрээнд түүхэн бие хүмүүсийн намтар судлал нь түүний нэгэн чиглэл болон тавигдаж түүгээр ХХ зууны эхэн үе, ялангуяа 1921 оны ардын хувьсгал ба түүний дараах нийгмийн хувьсгалт өөрчлөлтийн үйл хэрэгт хүчин зүтгэж байсан монголын төр, нам, цэргийн томоохон зүтгэлтэн бүхий түүхэн бие хүмүүс, нэг ёсны лидерүүдийн амьдрал, нийгэм-улс төр, цэргийн үйл ажиллагааг судлан илэрхийлж байжээ.

Манай оронд 1990-ээд оноос өмнөх үед түүх, философи, төр, эрх зүйн асуудал, зарим тохиолдолд монголын уран зохиол судлалаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын дотроос монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээр хийгдсэн судалгаа, түүний үр дүнд гарсан ном зохиолууд өнөөгийн улс төрийн шинжлэх ухаанд шууд учир холбогдолтой, ихээхэн ач тустай байгааг онцлон тэмдэглэвэл зохино. Учир нь улс төрийн сэтгэлгээ, сургаалын түүх бол улс төрийн шинжлэх ухааны бүтэцэд чухал байр суурь эзэлдэг, түүний үзэл санааны түүхийг бүрдүүлдэг онцлогтой.

Энэчлэн 1990-ээд оноос өмнө монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхээр хийгдсэн судалгаа, ялангуяа академич Ч.Жүгдэрийн туурвисан цуврал суурь бүтээлүүд, түүнчлэн академич Ш.Нацагдорж, доктор Д.Дашжамц, Г.Гэлэг зэрэг эрдэмтэдийн ном зохиолууд манай их, дээд сургуулиудын мэргэжлийн анги, салбар, тухайлбал МУИС-ийн улс төр судлалын салбарт тусгайлан ордог монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн хичээл сургалтад гол гарын авлага болж хэрэглэгдэж байгаа юм.

1990-ээд он хүртлэх үед манайд хийгдэж байсан улс төрийн аспекттэй судалгаа, боловсруулалтын хүрээн дотор улс төрийн ерөнхий мэдлэг бүрдүүлж бий болгох, түүнийг холбогдох сурах бичиг, гарын авлага, сэдэвчилсэн эмхтгэл, толь бичиг, лавлах материал зэрэг хэлбэрээр эмхлэн системчилж их, дээд, тусгай, дунд болон техник-мэргэжлийн сургуулиудын оюутан, суралцагчид, нам, үйлдвэрчний



болон залуучуудын эвлэлийн улс төрийн сургуульд зориулж нийтлэн гаргаж байсан билээ. Тэр цагт одоогийн улс төрийн шинжлэх ухааныг албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүй, бие даасан тусгай шинжлэх ухаан гэж үздэггүй байсны улмаас түүний онолын мэдлэгийн тогтолцоог "улс төрийн мэдлэг", "улс төрийн мэдлэгийн үндэс" гэх зэргээр нэрлэн томъёолж марксист онол, сургаалын үндсэн дээр боловсруулж нийтэд судлуулан түгээж байв. Тэрхүү судалгаа боловсруулалт, сургалт сурталчилгааг хэвлэл нийтлэлийн баримт болж гарсан ном бүтээл нэлээд бий бөгөөд тэдгээрийн заримыг дурдвал: Улс төрийн товч толь.УБ.,1964; Улс төрийн боловсролын анхны мэдэгдэхүүн.УБ.,1972; Б.Дүгэр.Нийгэм улс төрийн товч толь.УБ.,1973; Улс төрийн мэдлэгийн үндэс.УБ.,1975; Улс төрийн лавлах.УБ.,1986 гэсэн бүтээлүүд юм.

1920-иод оноос 1980-аад оны үед нам, улсын ажилтан, албан хаагч, ер нийт намын гишүүн хөдөлмөрчидэд улс төрийн мэдлэг, боловсролыг системтэй олгож эзэмшүүлэхэд ихээхэн анхаарч байсан бөгөөд эл асуудлыг түүхийн ухааны доктор Ж.Роозон судалгааны нэгэн сэдэвт бүтээлийн түвшинд шинжлэн судлаж "МАХН-ын улс төрийн боловсролын систем: үүсэл хөгжил, цаашдын төлөв" гэсэн номыг 1984 онд нийтлүүлсэн байна.

Авч үзэн буй үед хийгдсэн улс төрийн судалгаа, ерөөс ХХ зууны монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний хөгжлийн сан хөмрөгт Монгол Улсын 1924, 1940, 1960 оны 3 удаагийн Үндсэн хууль, МАХН-ын их, бүгд хурлуудын материал, тогтоол, нам, улсын удирдах зүтгэлтгүүдийн зохиол бүтээл чухал байр суурь эзлэнэ. Учир нь тэдгээр баримт бичиг, ном зохиол, материалд тухайн үеийн монгол улсын амьдралын дотоод гадаад төлөв байдал, асуудал, бэрхшээл, зорилт, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, баримталсан концепци тусгалаа олж судлагдан шинжлэгдсэн, үнэлэлт дүгнэлт өгөгдснийг тооцон анхаарах нь шинжлэх ухаанч хандлага, зарчимд нийцнэ.

Эл зүйлд өгүүлснийг хурааж тэмдэглэвэл ХХ зууны 20-иос 80-аад онд төр, нам, улс төрийн бусад үзэгдэл, үйл явдлын асуудлаар хийгдсэн улс төрийн судалгаа, түүний үр дүнд нийтлэгдсэн ном зохиол, бусад бүтээл, хуримтлагдсан туршлага, баримт материал, мэдээллийн бааз, дурдсан чиглэлээр судалгаа хийж, мөн их, дээд сургуульд хичээл зааж бэлтгэгдсэн эрдэмтэн судлагчид улс төрийн эрдэм мэдлэгт багагүй хүч нөөцийг бүрдүүлсэн байна. Чухам энэхүү оюуны хүч нөөц нь 1990-ээд оноос манай оронд орчин цагийн улс төрийн шинжлэх ухааны үндэс суурь тавигдаж цааш жигдрэн төлөвших, хөгжиж эхлэх хөрс дэвсгэр болж ашиглагдсан байна. Тиймээс манай оронд улс төрийн шинжлэх ухаан огт хоосон газар гэнэт бэлнээр бууж ирсэн юм биш гэдгийг онцлон тэмдэглэхийн хамт нөгөөтэйгүүр эл шинжлэх ухаан өөрийн онол, арга зүй, зарчим, бүтэц, зохион байгуулалт, судалгааны арга техникээрээ, нэг үгээр хэлбэл бие даасан шинжлэх ухаан болохын хувьд бидэнд шинэ зүйл байсаныг бас цохон тэмдэглэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл 1990-ээд оноос өмнөх улс төрийн судалгаа нь онол-танин мэдэхүй, нийтлэгдсэн ном зохиол, мэдээллийн бааз, багтаамжын хувьд хэдийгээр чухал ач холбогдолтой, үнэ цэнэтэй ч гэсэн өөрийн мөн чанар, шинжлэх ухааны статусаараа өрнийн орнуудад хөгжиж ирсэн улс төрийн шинжлэх ухаантай яг адил биш, зарчмын чанартай олон зүйл бүхий үзүүлэлтүүдээрээ өөр судалгаа байсан билээ. Тиймээс ч түүнийг тогтолцоогоор нь халах, гэхдээ үнэ цэнэтэй ололт, амжилт, нөөц хүчийг нь зүй зохистой хадгалан өөрчлөх, ашиглах замаар өрнийн жишигтэй улс төрийн шинжлэх ухааныг цоо шинээр цогцлоон бий болгох чухал бөгөөд бэрхшээлтэй нарийн зорилт зайлашгүй тавигдсан байна. Энэ зорилт өнөө үед амжилттай хэрэгжиж байгаа билээ.



**К вопросу о политических исследованиях, осуществленных  
в Монголии в 1920-1980-ые годы****Резюме**

Статья посвящена рассмотрению некоторых сторон вопроса о политических исследованиях, проводившихся в 1920-1980-ые годы монгольскими учеными и исследователями. Традиционная монгольская общественно-политическая мысль продолжалась приблизительно до начала 1920-х годов. С этого периода начинает складываться новая общественно-политическая мысль, основанная на марксистском учении и она дальше развиваясь, продолжалась до начала 1990-х годов. В рамках этого периода, охватывающего около 70 лет, в Монголии проводились многосторонние обществоведческие и политические исследования, посвященные рассмотрению и разработке политической истории страны и государства, партии и общественно-политических организаций, становления новых институтов власти, освещению политической биографии и деятельности исторических личностей, деятелей партии и государства, армии. За это время успешно исследована проблема внешней политики государства и международных отношений, ученые немало внимания уделили рассмотрению вопроса об идеологии, идейно-политическом воспитании и сознании масс. В 1980-ые годы некоторые ученые и специалисты начали проводить собственно политологические исследования по проблеме политической системы, политической культуры, сознания и т.д. Благодаря осуществлению вышеупомянутых политических исследований в отмеченный период, в отечественной общественной науке был накоплен немалый научный потенциал, опыт, подготовлен соответствующий состав научных работников и преподавателей вузов, специализирующихся по политическим проблемам. Именно этот научный потенциал послужил предпосылкой возникновения и основой формирования политической науки в стране с начала 1990-х годов. Следует отметить, что данный вопрос пока еще нуждается в специальном, основательном исследовании.

**Ашигласан ном зохиол**

1. БНМАУ-ын түүх. Гутгаар боть (Нэн шинэ үе). УБ., 1969
2. БНМАУ-ын соёлын түүх (1941-1960) Дэд боть. УБ., 1986
3. Дашжамц Д. Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд (XIX-XX зууны зааг) УБ., 1970
4. Дашжамц Д. Марксизм-ленинизм Монголд дэлгэрэн хэрэгжсэн нь (1917-1940). УБ., 1974
5. Дашжамц Д. БНМАУ дахь марксист сэтгэлгээний хөгжилт (1940-1960 он). УБ., 1978
6. Дэлэг Г. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 1965
7. Жүгдэр Ч. XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. УБ., 1972

8. Монголын түүх бичлэг, сурвалж судлалын ном зүй. Эмхтгэсэн Э.Жигмэддорж, Б.Пунсалдулам. УБ.,2009
9. Монгол-оросын түүх бичлэг дэх монголын эзэнт гүрэн. Эрдэм шинжилгээний хурлын материал. Эмхтгэсэн Б.Пунсалдулам. УБ.,2009
10. Пунсалдулам Б. 1911 оны монголын үндэсний хувьсгалын түүх бичлэг (1911-2003) УБ.,2006
11. Содномдаргиа Т., Мөнхдэлгэр Н. Монголын түүх бичлэг (Нэн эртнээс XX зуун). УБ.,2004
12. XX зууны эхэн үеийн монголын түүх судлалын ном зүй (1911-1920). Эмхтгэсэн Э.Жигмэддорж, Б.Пунсалдулам. УБ.,2010